



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/02

Бат-Өлзий сум

Цэргийн бүртгэл явуулах тухай.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, 34 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын “Цэргийн бүртгэл явуулах тухай” 2023 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны цэргийн бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 05-наас 2023 оны 01 дүгээр сарын 25-ны хооронд биечлэн болон цахимаар зохион байгуулсугай.

2. Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

Б.Орбиш (Нийгмийн ажилтан)

Г.Сарантуяа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Г.Дуламдорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

Ө.Гөлгөө (Улсын бүртгэгч)

3. Цэргийн бүртгэлийг зохион байгуулахдаа иргэдэд зар мэдээллийг хүргэн, иргэний цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэхийг үндэслэн биечлэн болон “e-Mongolia” гар утасны аппликейшнээр бүртгэхийг багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав, Д.Дэмиддагва) нарт даалгасугай.

4. Цэргийн бүртгэлийг Засаг даргын Тамгын газрын багийн Засаг дарга нарын өрөөнд заасан хугацаанд заавар журмын дагуу явуулж, дүн мэдээг 2023 оны 02 дугаар сарын 06-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

5. Цэргийн бүртгэл зохион байгуулахад шаардагдах 300,000 (гурван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөцөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

2023.01.003